



АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН УЛСЫН  
БҮРТГЭЛИЙН ГАЗАР, ХЭЛТСИЙН  
ДАРГА НАРТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**УЛСЫН БҮРТГЭЛИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗАР**

Цагдаагийн гудамж, 11 дүгээр хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14171  
Утас: 32 05 02, Цахим шуудан: contact@burtgel.gov.mn,  
Цахим хуудас: www.burtgel.gov.mn

2025.02.17 № 1/2025

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Зөвлөмж, чиглэл хүргүүлэх тухай**

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтад зааснаар “Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах”, 17.1.3 дахь заалтад “улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдүүлэх” эрхтэй гэж заасан бөгөөд мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална” гээд 4.1.1 дэх заалтад “нэгдмэл тогтолцоо, арга зүйтэй байх;” гэж заасны дагуу дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга, тэмдгийг аливаа этгээд зохих журмын дагуу хүлээлгэн өгөхгүй байгаа үйлдлийн улмаас хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хэрхэн бүртгэх талаар Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 1/19192 дугаартай зөвлөмжийг хүргүүлсэн бөгөөд уг зөвлөмжөөр холбогдох хууль тогтоомжийн заалтыг хэрхэн хэрэглэх талаар зааварчилсан боловч улсын бүртгэгч болон хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны дарааллын талаарх зааварчилгааг нарийвчлан тусгаагүйн улмаас холбогдох улсын бүртгэл хөтлөхдөө хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэх эсэх асуудлаар зөрүүтэй ойлголт үүссэн байна. Энэ нь дээр дурдсан улсын бүртгэл нэгдмэл тогтолцоо, арга зүйтэй байх, үйлчилгээний стандарттай байх зарчмыг зөрчиж байна.

Иймд уг асуудлыг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй улсын бүртгэлийн хууль тогтоомжийн хүрээнд хэрхэн шийдвэрлэх талаар Хяналт шалгалтын газар болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газрын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн хамтарсан хурлаар дараах байдлаар шийдвэрлэлээ. Үүнд:

1.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тамга, тэмдгийг аливаа этгээд өгөхгүй байгаа үйлдлийн улмаас холбогдох шийдвэр болон мэдүүлгийн маягтад тамга, тэмдэг дарагдаагүй, улсын бүртгэлийн гэрчилгээ эх хувиар байхгүй, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд нэгэнт солигдоогүйн улмаас холбогдох тодорхойлолт зэргийг хавсаргаагүй нь хуулийн этгээдийн мэдээлэлд оруулах өөрчлөлтийг бүртгэхээс татгалзах үндэслэл болохгүй талаар Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2024 оны 1/19192 дугаартай зөвлөмжид тодорхой тайлбарласан. Өөрөөр хэлбэл нэгэнт хуулийн этгээдийн шийдвэр гаргах эрх бүхий байгууллага нь хууль тогтоомжид заасан процессын дагуу, хуралдвал зохих ирцтэйгээр хуралдаж, тухайн шийдвэрийг гаргавал зохих хувиар шийдвэрлэсэн бол дээрх баримтууд байхгүй үндэслэлээр бүртгэхээс татгалзах нь иргэний эрх зүйн хүрээнд гарсан хүчин төгөлдөр шийдвэрийг үгүйсгэсэн захиргааны байгууллагын хууль бус үйлдэл бөгөөд

142501280



Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль зэрэг холбогдох хуулиудыг зөрчиж буй үйлдэл болно.

Хуулийн этгээдийн төлөөлөх эрх бүхий этгээдийг өөрчилсөн шийдвэр гарснаар Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 226 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журмын 6.8 дахь хэсэгт “Байгууллагын удирдлага өөрчлөгдөх болон тамга, тэмдэг түших албан тушаалтан солигдох, чөлөө авах, ээлжийн амралт авах, томилолтоор ажиллах, суралцах, эрүүл мэндийн шалтгааны улмаас эзэнгүй байх хугацаанд албан үүргийг түр орлон гүйцэтгэгч акт, бүртгэлээр тамга, тэмдгийг хамт хүлээлцэнэ.” гэж заасны дагуу өмнөх төлөөлөх эрх бүхий этгээд шинээр томилогдсон эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөх үүрэгтэй байхаар зохицуулсан бөгөөд харин тухайн шийдвэрийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзэж буй этгээд холбогдох хууль сахиулах болон шүүхийн байгууллагад хандахад дээрх шилжүүлэн өгөх үйл ажиллагаа нь саад болохооргүй байна.

Иймд улсын бүртгэгч Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 1/19192 дугаартай зөвлөмжид заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 208 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журмын 3.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол энэ журмын Долоо, Найм, Ес, Аравт заасан улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг эрх бүхий этгээдийн тамга, тэмдэг, гарын үсгээр баталгаажуулсан байна.” гэж заасны дагуу тамга, тэмдгийг шинээр томилогдсон эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөөгүй нөхцөл байдлыг сонсох ажиллагааны хүрээнд тогтоож улмаар гарын үсгээр баталгаажуулсан байдлыг шалгаж, тэдгээр нь эрх бүхий этгээд мөн эсэхийг тогтоосны үндсэн дээр хуулийн этгээдийн мэдээлэлд оруулах өөрчлөлтийг бүртгэх ба дээрх журмын хүрээнд гарын үсгээр баталгаажуулсан байдлыг шалгасан тохиолдолд журмын зөрчил гэж үзэхгүй.

2. Энэхүү зөвлөмжийн 1 дэх хэсэгт заасан бүртгэл хийгдсэнээр хуулийн этгээдийн эрх бүхий этгээдийн шийдвэр хэрэгжих боломж бүрдэж, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд бүртгэгдсэн гэж үзнэ. Энэ нь Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 226 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журмын 6.8 дахь хэсэгт “Байгууллагын удирдлага өөрчлөгдөх болон тамга, тэмдэг түших албан тушаалтан солигдох, ... албан үүргийг түр орлон гүйцэтгэгч акт, бүртгэлээр тамга, тэмдгийг хамт хүлээлцэнэ.” гэж заасан журам хэрэгжих эрх зүйн үр дагаварыг үүсгэнэ. Мөн журмын 6.1 дахь хэсэгт “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудсыг ажлын байранд цоожтой шүүгээ, сейфэнд хадгална.” гэж, 6.2 дахь хэсэгт “Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг албаны бус хэрэгцээнд ашиглах, бусдад шилжүүлэх болон ... бусад тохиолдолд ажлын байрнаас гадагш авч гарахыг хориглоно.” гэж тус тус зааснаар аливаа этгээд нь хуулийн этгээдийн тамга, тэмдгийг шилжүүлэн өгөхгүй байх, ажлын байрнаас авч гарах үндэслэлгүй юм.

Иймд дээрх үйлдэл нь тус журмын 7.1 дэх хэсэгт “Энэ журмыг зөрчсөн байгууллага, хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллагын үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.” гэж, Зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Тамга, тэмдэг үйлдвэрлэх хэрэглэх, хадгалах журам зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасны



дагуу зөрчлийн шинжтэй үйлдэл гэж үзнэ. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.20 дахь хэсэгт зааснаар Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэнэ. Мөн энэхүү зөвлөмж нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1.11, 1.12, 6.6 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтны эрхийг хязгаарлаагүй болохыг дурдах нь зүйтэй.

Түүнчлэн Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 128/ШШ2024/0479 дүгээр шийдвэрт “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэгт заасны дагуу “Улсын бүртгэлийн гэрчилгээ болон тамга, тэмдгийн хяналтын дугаарыг дараах үндэслэлээр дахин олгоно” гэж, мөн зүйлийн 8.8.4 дэх заалтад “гэрчилгээ болон тамга, тэмдгийг хаяж үрэгдүүлсэн” гэж заасны хаяж үрэгдүүлсэн гэдэгт хуулийн этгээдийн хүчин төгөлдөр гэрчилгээ болон тамга, тэмдгийг эрх бүхий этгээд /үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага/ компанийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй нөхцөл байдлыг ойлгох байтал бодит байдалд хуулийн этгээдийн тамгыг нуух, авч явах, хүлээлгэн өгөхгүй байх үйлдэл нь тухайн тамга, тэмдгийг хуулийн этгээдийн үйл ажиллагаанд ашиглах боломжгүй нөхцөл байдлыг ойлгоно.” гэсэн байна.

3. Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2024 оны 1/19192 дугаартай зөвлөмжөөр Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8.4, 8.9, 8.10 дахь хэсэгт заасныг нэг мөр хэрэглэх арга зүйг зааварчилсан ба харин дээрх заалтын хүрээнд хуулийн этгээдийн гэрчилгээ болон тамга, тэмдгийн өмнөх хяналтын дугаарыг хүчингүй болгохгүй байх нь дараах эрсдэлийг үүсгэж байна. Үүнд:

- Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нь хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаарыг өөрөө хүчингүй болгох үйлдэл хийх эрх хэмжээ олгогдоогүй тул зөрчил болохоор;

- Хуулийн этгээдэд хүчинтэй хяналтын дугаартай хоёр тамга, тэмдэг бий болж төөрөгдөл үүсгэх;

- Хуулийн этгээдийн устсан, хаяж үрэгдүүлсэн, эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөхгүй байгаа тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгоогүй тохиолдолд уг тамга, тэмдгийг өөр бусад этгээд ашиглах, хуулийн этгээдийн нэрийг барих, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд саад учруулах зэрэг хууль, эрх зүйн зөрчлүүд үүсэх эрсдэлтэй байна.

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалтад хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаарын бүртгэл нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн төрөлд хамаарахаар, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.1 дэх заалтад хяналтын улсын байцаагч хяналт шалгалтын явцад улсын бүртгэлийн хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчилтэй баримт бичиг, эд юмсыг акт үйлдэн хураан авч хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх, бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар дүгнэлт гаргах, зөрчлийг арилгах талаар холбогдох иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах эрх, үүрэгтэй талаар тус тус заасан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/216 дугаар тушаалын хавсралтаар баталсан Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын 5.2.4 дахь заалтад тамга, тэмдгийн хяналтын дугаар дахин



авахад бүрдүүлэх баримт бичигт улсын бүртгэлийг хүчингүйд тооцсон шүүхийн шийдвэр, эсхүл хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гэж журамласан байх тул хуулийн этгээдийн тамга, тэмдгийг аливаа этгээд шилжүүлэн өгөхгүй байгаа нөхцөл байдал Зөрчлийн тухай хууль болон Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.1 дэх заалтад заасан хяналт шалгалтын явцад тогтоогдсон тохиолдолд Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хүчингүй болгох дүгнэлт гаргахаар байна.

4.Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/216 дугаар тушаалын хавсралтаар баталсан Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын 5.2, 5.2.4 дэх заалтыг тус тус баримтлан нэгж дэх хяналтын улсын байцаагч Зөрчил шалган шийдвэрлэх хуулийн дагуу зөрчлийг шалган, хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаарыг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр хүчингүй болгосны дараа улсын бүртгэгч хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын дугаарыг олгох нь зүйтэй байна.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



У.БОЛДХҮҮ